

БАТЛАВ:
 ЗАСАГ ДАРГА С.МӨНХБААТАР
 2020.02.12

ТӨРИЙН АЛБАНЫ СУРГАЛТ БА МЭДЛЭГ ЧАДВАР БИЙ
 БОЛГОХ 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЖ
 АЖИЛЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2020.02.11

Сангийндалай

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хэрэгжилт
<i>Төрийн байгууллагуудмэдлэг чадвартай албан хаагчдтай болох зорилтын хүрээнд:</i>				
1	Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд дээд газраас батлагдан ирсэн хуваарийн дагуу сургалт семинарт хамруулах	Хуваарийн дагуу албан хаагчид сургалт, семинарт хамрагдсан байх	Жилдээ	Дээд газраас батлагдан ирсэн хуваарийн дагуу ЗДТГ-ын мэргэжилтэн албан хаагчдаас Засаг дарга, Тамгын дарга нар Дундговь аймгийн ЗДТГ-ын цэргийн штабаас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө батлуулсан. Мөн Дундговь аймгийн ХАА-н газраас зохион байгуулсан “Улсын бүртгэлд бүртгэлтэй хоршоодоос судалгаа авах зааварчилгаа” сэдэвт сургалтад нягтлан А.Соёл-Эрдэнэ, Ж.Хишигсүрэн, Байгаль орчны байцаагч С.Батбаяр Дроны зураглал ба боловсруулалт онол практик хосолсон сургалтанд, Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн үйлчилгээг цахимжуулах, үйл ажиллагааг операторын горимд шилжүүлэх төслийн сургалтанд бичиг хэрэг архивын ажилтан С.Оюунгэрэл нар тус тус хамрагдлаа. Мөн УИХ-ын болон орон нутгийн сонгуультай холбоотой танхимын болон цахим сургалтад тухай бүр хамрагдсан.
2	ЗДТГ-ын Дарга төрийн албан хаагчдад Ёс зүйн дүрмийн талаар сургалт зохион байгуулах	Алба хаагч бүр Ёс зүйн дүрмийн талаар мэдээлэлтэй болно.	Жилдээ	Биелээгүй.

3	Сургалтын хэрэгцээг албан хаагчдаас санал асуулгаар авч байгууллагын хэмжээнд нарийн тодорхойлох	Албан хаагчдаас сургалтын хэрэгцээг тодорхойлсон санал асуулга авсан байна. Байгууллагад шаардлагатай боловсон хүчин болон сургалтыг тодорхойлж ажил зохион байгуулсан байна.	Жилдээ	Нийт алба хаагчдаас ажлын байрны тохь, тух болон цаашдын ажил үүргээ хэвийн явуулахад шаардагдах сургалтын хэрэгцээний талаар судалгааг авч нэгтгэсэн. Судалгаагаар алба хаагчид компьютерийн мэдлэгээ дээшлүүлэх, албан хэрэг хөтлөлтөө сайжруулах санал нийт судалгааны 70 хувийг эзэлсэн байна. Цаашид энэ талаарх сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.
4	Төрийн албан хаагчдын ажлын байрандаа суралцах орчин нөхцлийг бүрдүүлнэ.	Төсвийн байгууллага бүр албан хаагчдынхаа ажлын байрандаа суралцах орчин нөхцлийг бүрдүүлж сургалтын техник хэрэгсэл, танимтай болсон байна.	Жилдээ	Албан хаагчидын суралцах орчиныг нэмэгдүүлж ажилаа хэвийн явуулахад туслах зорилгоор алба хаагчдын техник хэрэгслийг шинэчилсэн. Үүнд: 2,4,5-р багийн Засаг дарга нар болон ЗДТГ-ын дарга, ЗДТГ-ын нягтлан бодогчийн компьютерийг шинэчлэлээ.
5	Мэргэжилтэн бүр сонсгол мэдээллийн цагаар хууль эрх зүйн талаар мэдээлэл сургалт хийх	Салбар бүрийн чиглэлээр хууль зүйн мэдлэг дээшилнэ.	10.1-04.01	16 удаагийн сонсгол мэдээллийн цагаар 477 иргэн, албан хаагчид хууль эрх зүйн мэдээ мэдээллээр хангагдсан. Энэ оны 10 дугаар сараас сарчилсан хуваарийн дагуу хэвийн явагдана.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

НБХ МЭРГЭЖИЛТЭН:

Т.УРАНГОО